

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234712

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛДҮҮЛЭХ ХЭВТ ӨГҮҮЛЭХҮҮН НЬ
ГИШҮҮНИЙГ ҮЙЛДЭХ БА ӨГӨХ-ОРШИХЫН ТИЙН
ЯЛГАЛААР ЗАХИРАХ НЬ

Б.Мөнгөнцэцэг

Түлхүүр үг: үйлдүүлэх хэвт өгүүлэхүүн, үйл үндсийн утга, хэлний бус хүчин зүйл, үйлийг үйлдэгч эзэн, өгөх оршихын тийн ялгал, үйлдэхийн тийн ялгал

Бид энэхүү өгүүлэлдээ тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлбэрийн үйлийг үйлдэгч эзэн нь өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржих нь үйлдүүлэх хэвийн утгаас гадна тийн ялгалын утгатай хэрхэн холбогдож байгаа, түүнчлэн үйлдүүлэх хэвт өгүүлбэрийн ижил бүтцэд илрэх утгыг тодорхойлохдоо хэлний ба хэлний бус хамааралт үзэгдэл, зүй тогтол ямар учир холбогдолтой байгааг тодорхой жишээн дээр шинжлэн тайлбарлахыг зорилоо.

Үйлдүүлэх хэв нь үйлийг өөрөө бус, бусад этгээдээр хийлгэхэд чиглэсэн хэл зүйн хэрэглүүр юм. Үйл үгийн үндсэнд -уул (-үүл), -лга (-лгэ, -лго, -лгө), -га (-гэ, -го, -гө), -аа (-ээ, -оо, -өө) дагаврыг залгаж тус хэвийг илрүүлнэ. Угтаа үйлдүүлэх хэвийн бүтээврүүд гарал нэгтэй боловч хэлний хувьслын үр дүнд дээр дурдсанчлан дөрвөн хувилбартай болсон байна. Зарим судлаачид хэвийн бүтээврийг үйл язгуур, үндсээс үйл үг бүтээх дагавар (Поппе, 1937:140-143; Ринчен, 1956:189-218; Санжеев, 1958:4; Дондуков, 1964:144-151; Лувсанвандан, 1968:140-143; Өнөрбаян, 2000:51-62), зарим нь хэл зүйн харьцаа заах нөхцөл буюу үг хувилгах дагавар (Лувсанвандан, 1961:291; Бямбасан, 1970:230-231; Түмэнжаргал, 2018: 228-232) гэж хоёр янзаар үздэг. Гэхдээ энэ нь үг бүтээх дагавар, үг хувилгах нөхцөл болчхоогүй, өөрөөр хэлбэл, үг бүтээх дагавар, үг хувилгах нөхцөл хоёрын завсрын шинжтэй. Монгол хэлний хэвийн бүтээврийн дараа зарим нэр үг бүтээх дагавар ордог. Жишээ нь: байгууллага, даалгавар, жагсаалт, дасгал, ухагдахуун, тулалдаан, туслалцаа. Түүнчлэн үйлдүүлэх хэвийн дагавар давхарлаж ордог талаар тухайлбал, П.Бямбасан “Үйлдүүлэх хэвийн хоёр шат үүсгэж байгаа хэлбэрүүд нь тус бүр эзэн биеийн харьцааг заана. Жишээлбэл: Одоо би хариад (Оюунчимэгийг) зарцаар хүргүүлье (Д.Н) гэсэн өгүүлбэрт хүрэх үйлийн жинхэнэ гүйцэтгэгч эзэн нь Оюунчимэг юм. Энэ нь өөрөө үйлдэх хэвд “Оюунчимэг хүрнэ” байх ёстой. Үйлдүүлэх хэвийн I шатанд “Би (эзэн) Оюунчимэгийг хүргэнэ” гэж байх ёстой болно. Үйлдүүлэх хэвийн II шатанд “Би Оюунчимэгийг зарцаар хүргүүлнэ” гэж байх болж, үйлдүүлэх хэвийн -га,

-уул хоёр нөхцөл тус тус эзэн биесийн харьцааг зааж байна” (Бямбасан, 1987:56-57) гэжээ. Нэг үгэнд нэг төрлийн нөхцөлүүд ордоггүй бөгөөд хэвийн бүтээвэр давхарлан орж байна гэдэг нь үг бүтээх дагаврын шинжтэйг давхар нотолж байна. Үүнээс үүдээд эдгээр бүтээврүүдийн байрлал, утга ямар зүй тогтолтой байгааг энэ онцлогтой нь холбон үзэж болно. Учир нь, үгийн бүтцэд орж байгаа бүтээвэр үгийн үндсээс хойшлох тусам хамрах үгийн хүрээ буюу залгаж болох үгийн тоо ихэснэ. Нөхцөлтэй харьцуулахад хамгийн бүтээлч дагавар ч харьцангуй цөөн үгэнд орно. Тэгэхээр хэвийн дагавар орох үгийн хүрээ ч цөөн байна гэсэн үг. Цөөн байгаагийнхаа хувьд, ямар ямар төрлийн үйл үндсэнд тохиолдож, тэр нь ямар ямар утга санаа илэрхийлж байгааг нарийвчлан үзэх шаардлагатай болно.

Монгол хэлний үйл үгэнд идэвхтэй ба идэвхгүй шинж байдаг талаар судлаачид бүтээлдээ тэмдэглэсэн байна. Тухайлбал: Г.Д.Санжеев (1963) монгол хэлний үйл үгийг идэвхтэй, идэвхгүй гэж хоёр хуваасан. Үйл үгийн идэвхтэй ба идэвхгүй шинж нь бодит ахуйн учир зүйг тусгасан, үйл үгийн нь утгын шинж юм. Үйлийн эзэн өөрийн эрх зоргоор үйлдэж биелүүлэх үйлийг идэвхтэй үйл үг гэнэ. Жишээлбэл: бичих үйлийг үйлийн эзэн гүйцэтгэх бөгөөд бичих, бичихгүй нь гүйцэтгэх эзний дур хүслээр болж болно. Үүнчлэн унших, явах, суух, ярих, хэлэх, идэх, харах гэх мэт үйл үг идэвхтэй үйл үг юм. Үйлийн эзний дур хүслээс шалтгаалахгүй, үйлийн эзэнд учирч тохиолдох, үйлийн эзэн эдлэх үйлийг идэвхгүй үйл үг гэнэ. Жишээлбэл: өтлөх, үхэх, цайх, халах, хатах, шатах, өвдөх, төрөх гэх мэт. Идэвхтэй үйл үг нь унших, бичих, үзэх, харах гэх мэт тусах; явах, суух, хэвтэх гэх мэт эс тусах байх боловч идэвхгүй үйл үг нь зөвхөн эс тусах байна. Ийнхүү Г.Д.Санжеевийн бичсэнээр монгол хэлний үйл үг тусах ба эс тусах, идэвхтэй ба идэвхгүй шинжээрээ “1. Идэвхтэй-тусах буюу тусах идэвхтэй, өөрөөр хэлбэл, зөвхөн тусах, 2. Идэвхтэй-эс тусах буюу эс тусах идэвхгүй, 3. Идэвхгүй-эс тусах буюу эс тусах-идэвхгүй” гурван янз байна.

Монгол хэлний үйл үгийг идэвхтэй, идэвхгүй гэж ангилдаг нь хүн, амьтан, юм гурвын хоорондын харилцан хамааралтай шууд холбоотой юм. Монгол хэлний үгсийг бүтээгч утга бүхий хэсэг нь өөр хоорондоо нягт холбогдож утгын хувьд шүтэн барилдаж байж сая цогц нэгэн утгыг үгээр дамжуулан хүний оюун, сэрэл сэтгэхүйд хүргэдэг бөгөөд “үгийн дагавар нь язгуураасаа ангид ямар ч утга илтгэсэн дохио болж чадахгүй, үүнчлэн үгийн цэвэр язгуур нь дагавраасаа ангид тодорхой утгатай дохио болж чадахгүй юм” (Лувсанвандан, 1968:101). Энэхүү “... тогтсон байрлал, дарааллын дагуу бүтээврүүд өөр хоорондоо шүтэн барилдаж, утга дамжилсан байдалтай болж, язгуур бүтээвэр хамгийн ерөнхий утгыг хадгалж, дагавар, нөхцөлийн илэрхийлэх утгаар улам тодорхой, илүү хийсвэр болдог байна” (Бадамдорж, 1997:146). Иймд бид үйл үгийг утгаар нь “А.1. Орших утга, 2. Харьцааны утга, Б.3. Өөрөө аяндаа хөдлөх, 4. Өөрийн эрхгүй хөдлөх, 5. Өөрийн эрхээр хөдлөх, В.6. Тусган хөдлөх, 7. Бүтээн хөдлөх, 8. Бүтээлгүй хөдлөх” (М.Базаррагчаа, 1985:198-199) гэж ялгасан ангиллыг баримтлан, монгол хэлний үйлдүүлэх хэвийн дагавар авах эсэх нь чухам ямар үндсэнд залгаснаас хамаарч байгааг шинжлэн үзсэн бөгөөд улмаар эдгээр дагаврыг залгаж байгаа үйл үндсийг үгийн сан-утгын орноор нь бүлэглэн авч үзлээ. Үүнд:

А. 1. Танихуйн үүднээс байгаль дээр орших амьтай, амьгүй аль ч юмны хөдөлгөөн нь анхнаасаа “өөрөө” хөдлөх шинжтэй байгааг “амьтай: *унт-*, *даар-*

, өлс-, өвд-, осго-, хөлд-, инээ-, баяс-, мишээ-, гут-, гунь-, сэр-, үх-, төр-, өс-, өтөл-, бээр-, уйл-, чичир-, бөөлж-, ай-, цоч-, эмээ-, гайх-, сандар-, мэгд-, догдол-, шанал-; амьгүй: урс-, найга-, шуугь-, орги-, цай-, гий-, улай-, бүдгэр-, гоож-, үлээ-” гэсэн бүлэг үгсээс харж болно. Хүн бол өөрөө хийдэг тусгай үйлээс гадна өөр ямар нэг юмыг өөрийн дур зоргоор эрхшээх байгалиас заяамал шинжтэй байдаг учраас байгалийн зарим юмсын “аяндаа” буюу өөрийн эрхгүй хөдлөх утгатай бүлэг үгс үйлдүүлэх хэвийн дагавар авдаг байна.

2. “Өөрийн эрхээр шилжилгүй хөдлөх: бос-, суу-, хөрвө-, жий-, хөмөр-, бөмбөр-, тэл-, залбир-, завил-, найга-, дэлгэ-; өөрийн эрхээр шилжин хөдлөх: яв-, ир-, оч-, од-, хүр-, шогш-, давхи-, гүй-, алх-; туул-, дав-, гатал-, харай-, дайр-, дайл-; эргэ-, тойр-; хэс-, зорч-, өнхөр-, гулс-, сал-, нийл-, өгс-, уна-, авир-, хөөр-, цув-, жагс-, зугт-, ор-, гар-, шингэ-, дус-, шурга-, шумба-” гэсэн бүлэг үгс нь шууд утгаараа хэрэглэгдвэл зөвхөн хүн амьтны биеэр (өөрөө) үйлдэх үйлийг заадаг учраас үйлдүүлэх хэвийн дагавар авдаг байна.

Б.3. “Сэтгэхүй: бод-, мэд-, сана-, дурс-, тахь-, шинж-, судал-, шийд-, шүт-, ятга-; бие: нэм-, ач-, арч-, барь-, бөглө-, буд-, бул-, зас-, өлгө-, ав-, өг-, сийл-; бие сэтгэхүй: зур-, бич-, судал-, тань-, туурви-, унш-, тайл-, ялга-, сонго-; хэл: ярь-, хэл-, магт-, шагш-, орчуул-” гэсэн бүлэг үгс нь үгийн сангийн утгаараа ялгарч хэдийгээр өөр өөр үйлийг илтгэж байгаа боловч бие, хэл, сэтгэхүйгээр бүтээн хөдлөх утга илтгэх шинжээрээ нэгэн бүлэг болон нэгдэж байна.


4. “Бие сэтгэхүй: бас-, март-, сонж-, сэрд-; бие: асга-, бар-, дүр-, бүл-, гөж-, эвд-, нүд-, хая-, занч-, цохь-, зажил-, зор-, сав-, нух-; сэтгэхүй: гөж-, дөнгө-, хяс-; хэл: хараа-, гүтгэ-, зүх-, зана-, шаард-, тушаа-” гэсэн бүлэг үгс нь бие, хэл, сэтгэхүйгээр бүтээлгүй хөдлөх утга илтгэх шинжээрээ нэгэн бүлэг болж байна. Үгийн сан-утгын орноороо хүний сэрэл мэдрэхүйд тусаж мэдээлэл өгөх шинжтэй дээрх үйл үндсийн ихэнхэд нь бусдаар үйлдүүлэх хэвийн -уул, -лга, -га, -аа гэсэн хувилбарууд, ялангуяа “-уул” дагаврыг залгахад тухайн үйлийг хүний эрхээр үйлдэх үйлийг заасан утга илэрхийлж байна.

В. 5. “Нүд: үз-, хар-, ширт-, ань-; чих: сонс-, чагна-, дуул-; хамар: шинш-; ам: амс-, шим-, хөх-, үлгэ-, гувш-, долоо-; арьс: тэмтэр-” гэсэн бүлэг үгс нь мэдрэхүйн эрхтнээр тусган хөдлөх утга илтгэх шинжээрээ нэгэн бүлэг болж байна. Хүний таван мэдрэхүй дотроос “үзэх, сонсох” хоёр нь хол ойр байгаа аль ч зүйлийг мэдэрч чадах боломжтой байдаг. Үүнтэй зэрэгцээд үзэгдэх, сонсогдох юм нь хэрэв харьцангуй алс хол байгаад уг юм бас өөрийнхөө үйлдлээр эсвэл өөр юмны нөлөөгөөр үзэх, сонсох мэдрэхүйд өртөхүйц орон зайд “орж ирэх” боломжтой байгаагаас шалтгаалж уг үйлийг тэмдэглэсэн “үз-, сонс-” гэсэн үгэнд үйлдэгдэх, үйлдүүлэх утгатай бүтээврийн аль аль нь орох боломжтой байна. Гэтэл амтлах нь уг эрхтэн тухайн юманд шууд хүртэхээс өөрөөр мэдрэх боломжгүй. Ийм учраас “*амсагдах, хөхөгдөх, долоогдох, үлгэгдэх” гэж хэлэх боломжгүй. Харин үнэрлэж мэдрэхүй нь амтлахыг бодвол хүртэгчээс харьцангуй хол орон зай дахь юмыг мэдэрнэ. Тийм учраас эдгээр бүлэг үг нь үйлдүүлэх хэвийн бүтээврийг авах тухайд үзэх, сонсох мэдрэхүйг илэрхийлдэг үйл үгийнхтэй адил зүй тогтолтой байна. Үүнээс үзвэл, үзэх, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэх мэдрэхүйг заасан үйл үгс нь үйлдэгдэх, үйлдүүлэх хэвийн дагаврыг авч байгаа нь тухай тухайн мэдрэхүйн эрхтний физиологийн төрөлхийн чадамжтай холбоотой

байна. Гэтэл “ид-, уу-, үмх-, залги-, ооч-, балга-“ гэх мэт үйл үг бий. Эдгээр нь хүн, амьтны рефлексийн шинжийг заахын хувьд өмнө жишээлсэн өөрөө хөдлөх үйлд хамаарах мэт боловч хүн, амьтны онцгой үйлийг заахын хувьд үйлдүүлэх хэвийн дагаврыг авах боломжтой байна.

Монгол хэлний үйл үгийн хэвийн асуудалд үйл үгийн тусах, эс тусах чанар шууд холбогдолтой. Монгол хэлний өгүүлбэрийн цөм бүтцийг тусах ба эс тусах үйл үгээр ялгадаг. Үйл үг нь өмнөх жинхэнэ нэрээ нэрлэх, заахын тийн ялгалаар захирснаас болж өгүүлбэрийн цөм бүтэц бий болдог байна. Ямар учраас энэ хоёр тийн ялгалыг цөм бүтэц үүсгэх хэрэглүүр болгосон бэ гэвэл а) нэрлэхийн тийн ялгал нь уг юмсын бодитой оршин байгааг буюу тухайн юмс уугуул шинжээрээ оршин байгааг заадаг учраас цөм бүрэлдэхүүний нэг гишүүн болно. б) Хүн ертөнц дэх юмс үзэгдлийг аль болохоор өөрийн болгон, түүнийг таньж мэдэх гэсэн үүднээс бусад олон төрлийн зүйл дотроос тухайн юмыг онцлон ялгах гэсний үүднээс заахын тийн ялгал чухал хэрэгтэй болдог. Иймд нэрлэхийн тийн ялгал нь бүх юмны орших түгээмэл утгыг заадаг учраас ил нөхцөл хэрэглэдэггүй бөгөөд зөвхөн үйлийн эзэн л нэрлэхийн тийн ялгалд байна. Харин заахын тийн ялгал нь тухайн юм нөгөө юм ба эзэнд өртөх утгыг заадаг. Монгол хэлний хэвийн дагавар нь цөм өгүүлбэрийн бүтцийг хувиргаж, цөм бус өгүүлбэрийг бүтээнэ. Жишээгээр тодруулъя. *Буантай ах минь, орох оронгүй ядуу намайг гомдуулахгүй биз дээ (Б.Ринчен)* гэсэн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлдүүлэх хэвээр хэлбэржсэн тул цөм бус өгүүлбэр болно. Үүнийг цөм өгүүлбэр болговол *Би эс гомдоно.* гэсэн хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр болох аж. *Балгармаа тэр шөнө байцаалган хянуулж...* (*Д.Нацагдорж*) гэхэд Балгармаа хэдийгээр үйлийн эзэн мэт боловч үйлэнд өртөж буй эзэн юм. *Тэд Балгармааг байц (аа)-н, хянаж...* гэвэл цөм өгүүлбэр болно.

“Үйл үгийн хэвийн дагавруудаас бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврууд тусахыг тусах хэвээр, эс тусахыг тусах болгон өөрчилдөг түгээмэл зүй тогтолтой.



Түүнчлэн монгол хэлний судлалд үйлдүүлэх хэв, үйлдэгдэх хэв хоёр ойролцоо утгатай, үйлдүүлэх хэв үйлдэгдэх хэвийн оронд хэрэглэгддэг. Энэ нь үйлдэгдэх хэв үйлдүүлэх хэвээс гарсантай холбоотой гэж үздэг. Тэгээд ямар тохиолдолд энэ хоёр хэв нэг нь нөгөөгийнхөө оронд нөхөн хэрэглэгддэгийг тодорхойлж

байна. Энэ тухайд П.Бямбасан “...иймэрхүү зүйлийг нэг нь нөгөөгийнхөө оронд хэрэглэгдэж байгаа бүр ижил утга, үүрэгтэй хоёр өөр хэлбэр гэж үзэж арай болохгүй мэт санагдана. ...Хэрэв өгүүлэгч этгээд адуу салхины хүчинд автагдсанд санаагаа төвлөрүүлбэл үйл үгээ үйлдэгдэх хэвээр, өөр зүйлд санаагаа төвлөрүүлсэн бол үйлдүүлэх хэвээр хэлбэржүүлнэ. Энэ нь хэв тус бүрийн утга үүргээс болох юм” (2006: 156-157) гэж үзсэн байна.

Үйлдүүлэх хэвийн дагаврыг тусах үйл үг, эс тусах үйл үгэнд залгах нь өгүүлбэрийн бүрэлдэхүүнд байх гишүүдийг тогтоох хэлбэржүүлэх талаар өөр байдаг бөгөөд үйлийг үйлдэгч эзэн нь ямар тохиолдолд заах, өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржихийг тодруулан авч үзье.

1. *Эс тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлэхүүн нь заахын тийн ялгалаар хэлбэржсэн гишүүнийг захирах нь:*

Эс тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлбэрийн үйлдэгч эзэн нь заахын тийн ялгалаар хэлбэрждэг талаар судлаачид санал нэгтэй байна. Тухайлбал, К.С.Ивченков “учир зүйн үүднээс эс тусах-үйлдүүлэх хэллэг нэг ч объектгүй хоёр субъектгүй байна. Нэгдүгээр гол субъект нь хоёрдугаараа сэдэж хоёрдугаар субъект нь үйлийг шууд гүйцэтгэнэ. Хэл зүйн талаар нэгдүгээр субъект нь нэрлэх, гарахын тийн ялгалд байж, өгүүлэгдэхүүн болох бөгөөд хоёрдугаар нь заахын тийн ялгалд байгаа шууд тусагдахуун болно (1958: 128-130, 135, 136), Д.Отгонсүрэн “эс тусах- үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрийн жинхэнэ эзэн нь заахын тийн ялгалаар (Ээж дүүг долоон цагт босгов) хэлбэржинэ (1982:50), П.Бямбасан “Ингээд голлох бүтцэд өгүүлэгдэхүүн байсан үг шууд тусагдахуун болно. Ийм шууд тусагдахуун нь хэл зүйн үүднээс тухайн үйлийг жинхэнэ биечлэн гүйцэтгэх эзэн нь болох учраас эс тусах үйл үгээс үүссэн үйл өгүүлэхүүнтэй хэллэгийн үйлийг биечлэн гүйцэтгэгч эзнийг заасан нэр үг нь заахын тийн ялгалд байдаг. ...Эс тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвд байгаа үйл өгүүлэхүүнтэй өгүүлбэрийн үйлийг жинхэнэ биечлэн гүйцэтгэгч эзнийг заасан үг өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар огт хэлбэржихгүй” (1987:59-60) гэжээ. Жишээгээр тодруулъя. *Ахынх нүүнэ* гэсэн цөм өгүүлбэрийн эс тусах үйл өгүүлэхүүнийг үйлдүүлэх хэвээр хэлбэржүүлэхэд өгүүлэгдэхүүн байсан гишүүн нь шууд тусагдахуун болохын зэрэгцээ тухайн үйлийг сэдэн үйлдүүлэх өөр нэг эзэн нэмэгдэж, улмаар гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр бүтнэ. “Маргааш би ахынхыг нүүлгэнэ” гэхэд “нүү-” гэсэн эс тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлэхүүн нь уг үйлийг сэдэн санаачлагч эзэн (би)-г нэрлэхийн тийн ялгалаар, уул үйлийг гүйцэтгэгч эзэн (ахынх)-г заахын тийн ялгалаар захирсан байна. Харин “маргааш” гэдэг нь уг үйлд шууд өртөхгүй тул зөвхөн уг үйлийн болох цагийг заахын зэрэгцээ өгүүлбэрийн дотоод бүтцэд төдий л нөлөөлөхгүй юм. “Манай эмч нар мэс заслаар өвчтөнд эрүүл бөөр амжилттай суулгаж байна” гэсэн өгүүлбэрт суулгагдах үйлийн жинхэнэ эзэн нь өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржсэн “өвчтөн” биш, “бөөр” болох аж.

“Эс тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвд байгаа үйл үгээс шалтгаалж өгүүлбэрийн бүрэлдэхүүнд байх үгс нь уг үйлийг сэдэн санаачлагч эзнийг заасан нэр үг, уул үйлийг жинхэнэ биечлэн үйлдэгч буюу эдлэгч эзнийг заасан нэр үг байна. ...Ийм бүтцэд үйлийн хоёр эзнээс гадна хэл зүйн шууд тусагдахуун

байдаггүй. Үүгээрээ тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвд байгаа үйл үгээс ялгарна” (Бямбасан, 1987:59).

2. *Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлэхүүн нь өгөх орших, үйлдэх, заахын тийн ялгалаар хэлбэржсэн гишүүнийг захирах нь:*

а. $N^{Зт\alpha} \rightarrow V_{\text{үйлдүүлэх хэв}}$: Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлэхүүн нь заахын тийн ялгалаар хэлбэржсэн гишүүнийг захирах тухайд судлаачдын санал зөрүүтэй байна. Тухайлбал, П.Бямбасан “Үйлдүүлэх хэвээр хэлбэржсэн тусах үйл өгүүлэхүүний жинхэнэ гүйцэтгэгч эзэн нь зөвхөн *Багш хүүхдийг кино үзүүлэв. Аав малаа даваа давуулав* гэх мэтийн үйлийн жинхэнэ эзэн нь идэвхтэй нэрээр, үйлэнд шууд өртөж байгаа зүйл нь идэвхгүй нэрээр илэрч байгаа бүтцэд заахын тийн ялгалаар хэлбэржиж болох юм. Гэвч ийм бүтэц нь ихэнхдээ *Багш хүүхдэд кино үзүүлэв. Ах малаа даваагаар давуулав* гх мэтээр ижил хоёр хэлбэржилтээс зайлсхийж өөр тийн ялгалаар хэлбэржсэн, өөр хувилбараар солигдох эрмэлзэлтэй байдаг” (2006:152) гээд, үйлийг жинхэнэ гүйцэтгэгч эзэн нь заахын тийн ялгалаар ховор хэлбэрждэг, мөн заахын тийн ялгалаар хэлбэржиж болох ганц тохиолдол нь ч заавал шаардлагатай биш болохыг дурджээ. Тэрээр үйлийг гүйцэтгэгч эзэн нь заахын тийн ялгалаар хэзээ ч хэлбэржихгүй байх тохиолдлыг тодорхой жишээгээр үзүүлсэн бөгөөд “...энэ гурван тийн ялгалыг үйлдүүлэх хэллэгийн үйлийг жинхэнэ гүйцэтгэгчийг хэлбэржүүлэхийн хувьд Г.Д.Санжеев шиг адил эрхтэйгээр үзэж хараахан тохирохгүй бөгөөд бас К.С.Ивченков шиг заахын тийн ялгалаар хэлбэржихийг нь огт үгүйсгэж болохгүй юм” (2006:153) гэжээ. Харин Д.Отгонсүрэн “Тусах-үйлдүүлэх хэллэгийн үйлийн жинхэнэ эзэн заахын тийн ялгалаар байх тохиолыг тусах-үйлдүүлэх хэллэгт хамаарахгүй гэж санаж байна. Нөгөө талаар, бидний түүсэн жишээний дотор тусах-үйлдүүлэх хэллэгийн үйлийн жинхэнэ эзэн заахын тийн ялгалаар хэлбэржсэн жишээ бас гараагүй болно” (1982:44) гээд, П.Бямбасангийн дээр дурдсан жишээг “найруулгын хувьд доголдсон жишээ” гэж үзсэнтэй бид санал нэг байна.

б. $N^{\Theta\alpha.t\alpha} \rightarrow V_{\text{үйлдүүлэх хэв}}$; $N^{Y\alpha} \rightarrow V_{\text{үйлдүүлэх хэв}}$:

Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлэхүүн нь өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржсэн гишүүнийг захирах тухайд, К.С.Ивченков (1958) үйлдүүлэх хэвийн дагавартай тусах үйл үгээс шалтгаалж өгүүлбэрийн бүтцэд оролцож байгаа шууд бус субъект (үйлийн эзэн) ямар тохиолдолд үйлдэх, ямар тохиолдолд өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржихийг үйлдүүлэх хэвийн дагавраар хэлбэржсэн тусах үйл үг нэг бүрийн шинжид эрж, үйлдүүлэх хэвээр хэлбэржсэн тусах үйл үгийг шууд бус субъектээ үйлдэхийн тийн ялгалаар захирдаг тусах-үйлдүүлэх үйл үг, шууд бус субъектээ өгөх оршихын тийн ялгалаар захирдаг тусах-үйлдүүлэх үйл үг гэж хоёр хуваагаад тус бүр 40 гаруй үг жагсаажээ. А.Бобровников (1849:123), Д.Отгонсүрэн (1982:162) нар “тусах-үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрийн жинхэнэ эзэн нь хэн нэгнээр ямар нэг юм хийлгэсэн утгатай бол үйлдэхийн тийн ялгалаар, хэн нэгнийг ямар нэг юм хийхэд хүргэсэн утгатай бол өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржинэ” гэсэн бол П.Бямбасан “Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвд байгаа үйл үгээс шалтгаалж өгүүлбэрийн бүрэлдэхүүнд байх үйлийг биечлэн гүйцэтгэх эзнийг заасан үг нь өгөх орших, үйлдэхийн тийн ялгалын ямраар нь хэлбэржих нь тухайн нөхцөл байдалд өгүүлэгч этгээд санаагаа юунд төвлөрүүлснээс уг зүйлийг гүйцэтгэгч

эзэнд нь зориулсан утгатай байвал голдуу өгөх оршихын тийн ялгалаар, уг үйлийг хэнээр юугаар үйлдүүлэхэд санаагаа төвлөрүүлсэн бол үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржинэ” (1987:60) гэжээ. “Ер нь үйлдүүлэх хэвээр хэлбэржсэн үйл үг үйлийн эзнийг заасан үгээ ямар тохиолдолд нэрлэсэн гурван тийн ялгалын алинаар нь захирч байгаагийн учир шалтгааныг олж, тайлбарлахад хэцүү, хэл зүйн зүй тогтлоос гадна учир зүйн зүй тогтолтой холбоотой тусгайлан судалбал зохих маш нарийн төвөгтэй үзэгдэл юм” (Бямбасан, 1987:58)

Ямар нэг үйлийг үйлдэгчийг хамгийн идэвхтэйгээс нь хамгийн идэвхгүй рүү нь эрэмбэлбэл, хамгийн идэвхтэй үйлдэгч нь хүн, удаах нь амьтан, хамгийн идэвхгүй үйлдэгч нь юм болно. Тэгвэл үйлийг жинхэнэ гүйцэтгэгч эзэн нь үйлдэх, өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржиж тусах үйл үгэнд захирагдсан өгүүлбэрт илрэх утга үүргийн ялгамжааг нарийвчлан тодорхойлоход үйлдэгчийн энэхүү идэвхтэй, дундаж, идэвхгүй шинж нэлээд учир холбогдолтой байна. Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлбэрийн үйлийг гүйцэтгэгч эзэн нь өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржих нь үйлдүүлэх хэвийн утгаас гадна тийн ялгалын утгатай хэрхэн холбогдож байгаа, уг асуудалд хэлний ба хэлний бус хамааралт үзэгдэл, зүй тогтол ямар учир холбогдолтой байгааг дараах жишээнээс тодруулъя.

Чононд хонь бариулжээ гэхэд Д.Отгонсүрэнгийн үзсэнээр үйлийн жинхэнэ эзэн, үйл сэдэгчээ эрхшээн захирсан буюу “чоно” “хонь”-ийг эрхшээн бариулахад хүргэсэн утгатай. Уг өгүүлбэрт үйлийг үйлдэгч эзэн, үйл сэдэгч-субъект хоёул амьтан (*чоно, хонь*) байна. Чоно хонийг барьж идэх нь байгалийн шалгарал. Тэгвэл үйлийг үйлдэгч эзэн, үйл сэдэгч-субъект хоёрын аль аль нь дээрхийн адил амьтан бөгөөд бүтэц нь ч ижил бас нэг хувилбар авъя. *Бүргэдэд үнэг бариулжээ* гэхэд “бүргэд” “үнэг”-ийг эрхшээн бариулахад хүргэсэн утгатай байна. Энэ өгүүлбэрт шууд тусагдахуун байхгүй бөгөөд байгалийн шалгарал зохилдлогын үүднээс үнэг бүргэдэд хэдийгээр баригдаж болох хэдий ч утгыг нь нарийвчилбал, үнэг гэгч тэр зальт амьтан бүргэдэд бариулсныг үзвэл сэрэмж алдсанаас болсныг мэдэж болно.

Чононд хонь бариулжээ гэсэн өгүүлбэрийг **Чоноор хонь бариулжээ* гэж хувиргавал чоно урьд нь яагаад хонийг барьж чадахгүй байсан юм бол? гэж эргэлзэхэд хүрч болзошгүй. Өөрөөр хэлбэл, үйлийг үйлдэгч эзэн, үйлэнд шууд өртөж байгаа зүйлийн аль аль нь амьтан ч гэсэн тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлыг хүн хэрхэн тусгасан онцлогоос хамаарч ижил бүтэц, хувирмал бүтцийн хооронд утгын ялгамжаа үүсч байгаа нь хэлний хэл зүйн бүтэцтэй хамаагүй, харин хэлний бус хүчин зүйлээс хамаатай байгаа нь мэдэгдэнэ. *Бүргэдэд үнэг бариулжээ* гэсэн өгүүлбэрийг хувиргаж, (*Бат*) *Бүргэдээр үнэг бариулжээ* гэвэл бүргэдийг үнэг барихад сургаж дасгасан гэсэн утга илэрхийлэхийн зэрэгцээ өгүүлбэрийн бүтцэд хоёр эзнээс гадна шууд тусагдахуун нэмэгдсэн байна.

Дээрх жишээнд үйлийг үйлдэгч эзэн, үйл сэдэгч-субъект хоёрын аль аль нь амьтан (чоно-хонь, бүргэд-үнэг) байсныг “хүн-хүн” болгож, бүтэц нь ч ижил бас нэг хувилбар авъя. (*Ээж*) *Доржоор хонь бариулаа* гэсэн өгүүлбэрийн үйлдүүлэх хэв нь “Ээж Доржийг эрхшээн захирч барих үйлийг хийлгэсэн” утга илтгэх бөгөөд үйлийг үйлдэгч эзэн, үйл сэдэгч-субъект хоёул хүн, харин үйлэнд шууд өртөж байгаа зүйл нь амьтан байна. Энэ өгүүлбэрт хонь хэдийгээр тухайн цагтаа

хүнээс хурдан, бас булжимхай авч, ухаант хүний гараас гарахгүйн хувьд яаж ийгээд хүнд баригдсан гэсэн утгыг илэрхийлсэн байна. Уг өгүүлбэрийн утгыг зөв ойлгохын тулд энд хүн, амьтан хоёрын харьцаа хамаатал байгааг мартаж болохгүй.

Доржоор хонь бариуллаа гэсэн өгүүлбэрийн үйлэнд өртөж байгаа зүйл нь амьтан байсныг “юм” болгож хувиргая. (Ээж) *Доржоор мод бариуллаа* гэхэд үйлийг үйлдэгч эзэн, үйл сэдэгч-субъект хоёул “хүн”, үйлэнд шууд өртөж байгаа зүйл нь “юм” байгаа бөгөөд бүтэц нь дээрх өгүүлбэртэй яг ижил байна. Тэгвэл Дорж модыг барих дуртай байсан эсэх нь хамаагүй, модыг барихыг шаардах, хүсэхийн аль нэг аргаар Доржийн гарт модыг атгуулсан буюу түүгээр мод бариулсан хэмээсэн утгыг энэ өгүүлбэрээр илэрхийлжээ. Уг өгүүлбэрийн утгыг зөв тайлахын тулд тухайн өгүүлбэрт хүн, юм хоёрын харьцаа хамаатал байгааг бас зайлшгүй анзаарах хэрэгтэй болно.

Энэ бүхнээс үзэхэд, монгол хэлний үйл үгийг идэвхтэй, идэвхгүй гэж ангилдаг нь хүн, амьтан, юм гурвын хоорондын харилцан хамааралтай шууд холбоотой юм. Иймээс хүнд хамаагүй үйлийг заадаг ихэнх үйл үг үйлдүүлэх хэвийн дагавар авдаг нь бүх юмыг хүн захиран эрхшээх шинжтэй нь холбоотой байдаг байна.

Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлбэрийн үйлийг гүйцэтгэгч эзэн нь өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржихийг үйлдүүлэх хэвийн утгаас гадна тийн ялгалтай холбон тайлбарлаж болохоор байна. Тодруулбал, үйлийг үйлдэгч эзэн нь үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржсэн нь идэвхтэй, ялгасан, үйлийн эзэн нь тодорхой, үйл бүтээгч шинжтэй бол өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржсэн нь идэвхгүй, эс ялгасан, тодорхой бус, үйл хүлээсэн утгатай байна.

Тусах үйл үгээс үүссэн үйлдүүлэх хэвт өгүүлбэрийн үйлийг гүйцэтгэгч эзэн нь үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржихэд тухайн өгүүлбэрийн бүрэлдэхүүнд хоёр эзнээс гадна шууд тусагдахуун илэрч байна. Өгүүлбэрийн ижил бүтэц, хувирмал бүтцийн хооронд утгын ялгамжаа үүсч байгаа нь хэлний бус хүчин зүйлээс хамаарч шалтгаалцсан, тодруулбал, тухайн өгүүлбэрийн утгыг зөв ойлгохын тулд хүн, амьтан, юм гурвын харьцаа хамаатал байгааг анзаарах хэрэгтэй болно.

Ном зүй

Монгол хэлээр

Бадамдорж, Д. (1997). *Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс*. Улаанбаатар: Сүхбаатар ХК.

Базаррагчаа, М. (1985). *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар: Экимто хэвлэлийн газар.

Бямбасан, П. (1987). *Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт*. Улаанбаатар: Ардын Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр.

Бямбасан, П. (1970). Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв байдал, *Хэл зохиол судлал*, VIII, Улаанбаатар.

Бямбасан, П. (2006). *Монгол хэлний онол, бүтцийн асуудалд*. Улаанбаатар: Бодьмөр хэвлэх үйлдвэр.

Лувсанвандан, Ш. (1961). *Орчин цагийн монгол хэл*. Бээжин.

Лувсанвандан, Ш. (1968). *Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь*. Улаанбаатар.

Ринчен, Б. (1956). *Монгол хэлний зүйн бичиг*. Улаанбаатар.

Түмэнжаргал. (2018). *Одоо үеийн монгол хэл*. Хөх хот:Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо.

Отгонсүрэн, Д. (1982). *Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв, байдлын дагаврын найруулгын үүрэг*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэр.

Өнөрбаян, Ц. (2000). *Орчин цагийн монгол хэлний үгзүй*. Улаанбаатар.

Гадаад хэлээр

Бобровников, А. (1849). *Грамматика монгольско-калмыцкого языка*. Казань.

Дондуков, У-Ж. Ш. (1964). *Аффиксальное словообразование частей речи в бурятском языке*. Улан-Үдэ.

Ивченков, К. С. (1958). Субъективно- объективные отношения в монгольском побудительном обороте, *Филология и история Монгольских народов*. Москва.

Санжеев, Г.Д. (1958). Наклонения в монгольских языках, *Вопросы грамматики и истории восточных языков*. Москва-Ленинград.

Санжеев, Г.Д. (1963). *Сравнительная грамматика монгольских языков (Глагол)*. Москва.

Поппе, Н. (1937). *Грамматика письменно-монгольского языка*. Москва-Ленинград.

Abstract

In this paper, we consider non derived verb stem which connected with passive voice suffix according to the meaning in group and most of words that indicate the action doesn't belong to human, taking passive voice suffixes is depending on the order. Therefore, we aimed to explain close matter in the examples that agent active (human) average (animal) passive (thing) when original action performed agent who formed in dative, the meaning expressed in the sentence ordered by transitive verb. a. Action performed agent is animal, direct object is animal. b. Action performed agent is human, direct object is animal. c. Action performed agent is human, direct object is thing.

Ordering action is different with cause of action performed agent, object are human-human, human-animal, human-thing, animal-animal, animal-thing, thing-thing, some opportunities which to express, ordered by language structure, obviously depends on nonlinguistic factor.